

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
78 дугаар тогтоолын 18 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төр, хувийн хэвшилийн түншлэлийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Нэгжийн нэр:

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого,
зохицуулалтын газар

Албан тушаалын нэр:

Хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн асуудал
хариуцсан ахлах шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй
дүүрэг, Ж.Самбуугийн гудамж Засгийн
газрын XI байр, Улаанбаатар хот 15160

Хөдөлмөрийн нэхцэл:

Хэвийн

Онцгой нэхцэл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр, хувийн хэвшилийн түншлэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт, бизнесийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг авах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулалтыг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль эрх зүйн судалгаа, шинжилгээг хийж, үр дүнг Газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Хөрөнгө оруулалттай холбогдох журам, зохицуулалтыг боловсруулах, Төр хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын хамтын ажиллагаа хөгжүүлэх, төлөвлөх, тодорхойлох;
- 2.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;
- 3.Хөрөнгө оруулалтын таатай орчныг бурдүүлэхэд чиглэсэн бодлого, төлөвлөлтийг хийх;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Хөрөнгө оруулалт, бизнесийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар бодлого, арга хэмжээний санал боловсруулах;</p> <p>2.Монгол Улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;</p> <p>3.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>4.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;</p> <p>5.Төр хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын хамтын ажиллагаа хөгжүүлэх, төлөвлөх, тодорхойлох;</p> <p>6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн олон улсын туршлага, хандлага, хууль эрхзүйн орчныг судлан ТХХТ-ийн тухай хууль болон дагалдан журмуудыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.</p>	<p>Бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байх.</p> <p>Хөрөнгө оруулалтын дэмжлэг, арга хэмжээг тодорхойлсон байх.</p> <p>Холбогдох арга хэмжээг төлөвлөж, санал боловсруулсан байх.</p> <p>Холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байх.</p> <p>Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, төлөвлөн тодорхойлсон байх</p> <p>ТХХТ-ийн олон улсын туршлага, хандлага, хууль эрхзүйн орчныг судлан ТХХТ-ийн тухай хууль болон дагалдан журмуудыг боловсронгуй болгох</p>	<p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г, Т</p>

		боловсруулсан байна	
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;	Авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байх.	Г
	2.Хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах;	Шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байх.	Г
	3.Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт, хууль эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.	Г, Х
	4.Хөрөнгө оруулалт, бизнесийн орчинтой холбогдох хууль эрх зүйн судалгаа, шинжилгээг хийх.	Холбогдох, судалгаа шинжилгээг хийсэн байх	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Бодлого, эрх зүйн орчин бэхжүүлэх, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалт орж ирэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах, тогтоон үлдээх, холболтын сувгийг бий болгох үе шатанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	Асуудлыг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулсан байх.	Г, Х
	2.Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө мэдээлэл өгөх;	Арга хэмжээг уялдуулан зохион байгуулж, хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө мэдээлэл өгсөн байх.	Г, Х
	3.Хөрөнгө оруулалтын чиглэлээр төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах.	Хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байх.	Г, Х

4 дүгээр зорилтын хүрээнд	1. Нэгжийн удирдлагаас өгч буй үүрэг, цаг үеийн арга хэмжээнд оролцох, эргэн тайлагнах;	Үүрэг даалгаврын дагуу ажил, үүргийг хийж гүйцэтгэсэн байна.	Г
	2. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, нэгтгэх, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, ажил үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж, үнэн зөв тайлагнасан.	Г, Т
	3. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Х, Г
	4. Албан тушаалын чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах;	Хугацаанд нь чанартай тайлагнасан байна.	Г
	5. Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгаа, баримт бичгийг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г
	6. Албан тушаалын чиг үүрэгт хамаарах албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж, барагдуулах, мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г, Т
	7. Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Т, Г, Х
	8. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, төрийн албаны хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах.	ХОМ хугацаанд нь мэдүүлж, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.

Мэргэжил	-Бизнес ба удирдахуй /0411, 0412, 0413, 0416/; -эдийн засаг /0311/; -эрх зүй /0421/.
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх.
Туршлага	- Төрийн албананд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албананд 3-аас доошгүй жил ажилласан байх.
	<p style="text-align: center;">Дүн шинжилгээ хийх</p> <ul style="list-style-type: none"> - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөтгэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй.
Ур чадвар	<p style="text-align: center;">Асуудал шийдвэрлэх</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.
	<p style="text-align: center;">Багаар ажиллах</p> <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	<p style="text-align: center;">Бусад</p> <ul style="list-style-type: none"> -Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн байгууллага, холбогдох албан тушаалтан; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;

	<ul style="list-style-type: none"> - Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, гадаадын иргэн, хуулийн этгээд; - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд.
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<p>Албан тушаал: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  ТУ32861 0806236 9022010236 03 24 (Г.Дээс солдт)</p> <p>2025 оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ  Шийдвэрийн огноо: Дугаар: 078 1119282-07 Түүхийн №: 912995</p>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<p>Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: 20 25. 03. 24 Дугаар: A/80 (тамга/ тэмдэг)</p> <p>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (И.БАТХҮҮ)</p> <p>2025 оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>
